



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/99

Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.2, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 19.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын хувийн хэвшлийн “Отгоннаст”, “Ахмад”-ын эмийн сангуудад 1 дүгээр зэрэглэлээр эмийн сангийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг хоёр жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Орхонтуул сумын Рашаант тосгон, Шаамар сумын эргэлтийн эмийн санд мансууруулах эмээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаатайгаар олгосугай.

3. Орхонтуул сумын Рашаант тосгон, Цагааннуур, Шаамар сумдын эргэлтийн эмийн санд, Мандал сумын хувийн хэвшлийн “Таван Од”, “Ачтан”, Мандал сумын Хэрх тосгоны “Энхийн төлөө” эмийн сан, “Сэлэнгэ Монос” эм ханган нийлүүлэх байгууллагын мансууруулах эмээр үйлчлэх эрхийг, Сүхбаатар сумын хувийн хэвшлийн “Ариун Таван Хан” ариутгал халдваргүйтгэлийн байгууллагын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус нэг жилийн хугацаатайгаар сунгасугай.

4. Сүхбаатар сумын “Сэлэнгэ эм ханган нийлүүлэх” байгууллага, Баруунбүрэн сумын “Зууннаст” эмийн сан, Сүхбаатар сумын хувийн хэвшлийн “Энэрэлт үйлс”, “Хар-Од” эмэгтэйчүүдийн эмнэлгүүдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хоёр жилийн хугацаатайгаар тус тус сунгасугай.

5. Мандал сумын “Бурам” сувиллын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 6 сарын хугацаатайгаар сунгасугай.

6. Тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ